



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/07-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 7033-3019

Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.15 № 121
танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН
“ЭРДЭНЭМАНДАЛ ХӨГЖЛИЙН ДЭД
БҮТЭЦ” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.ЛОМБО
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн дулааны үнэ тарифыг эрх бүхий байгууллагаар батлуулалгүйгээр төсөвт байгууллага, ААН, айл өрхөөс нийт 363,173.4 мянган төгрөгийн халаалтын орлогыг төвлөрүүлсэн.
- Дулаан хэрэглэгч ААН, айл өрхөөс нийт 2,520.0 мянган төгрөгийн халаалтын орлогыг дутуу төвлөрүүлсэн.
- 2022 онд түлээ нүүрсний болон бусад зардлаас 19,554.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу НӨАТ-ын баримтгүй ажил гүйлгээнд зарцуулсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2022 оны төсвийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 7,500.0 мянган төгрөгийг хөрөнгө худалдан авсан.
- Хөрөнгө оруулалтын зардлаас 40,919.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг аймгийн ОНӨГ-ын зөвшөөрөлгүй бэлтгэсэн.
- Эрдэнэмандал сумын ИТХТ-ийн 2021.09.13-ны өдрийн 17 дугаар тогтоолоор ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сумын ЗДТГ-ын даргыг томилон ажиллуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Эрчим хүчний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн, бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс дээгүүр бөгөөд аудитын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газартай холбоотой дараах шийдвэрүүд гарсан байна. Үүнд:

1. Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 109/ШШ2022/0016 шийдвэрээр Архангай аймгийн Эрдэнэмандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Сумын дэд бүтцийг хариуцсан орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулах тухай” 05 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах, 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Архангай аймгийн Эрдэнэмандал сумын дулаан хангамжийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралт, эзэмшилт ашиглалтын гэрээ”-г үргэлжлүүлэхгүй байгаа Эрдэнэмандал сумын Засаг даргын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, гэрээг үргэлжлүүлэхийг даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 516 дугаар магадлалаар Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 16 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж шүүхийн асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус үйлдвэрийн газар нь сумын Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээгээр 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Эрдэнэмандал сумын ИТХ-ын тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18,201.72	32,703,860.82
1.1.2	Дансны авлага	-	2,520,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	1,363,117.00
1.1.6	Бараа материал	-	18,441,249.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,201.72	55,028,226.82
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	100,217,337.00
1.2.2	Биет бус хөрөнгө	-	1,056,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	101,273,337.00
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,201.72	156,301,563.82
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	8,653,936.21
2.1.1.3	Татварын өр	-	8,653,936.21
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	8,653,936.21
2.20	Өр төлбөрийн нийт дүн	-	8,653,936.21
2.3.1	а) төрийн	-	68,844,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	18,201.72	78,803,627.61
2.3.11	Эздийн өмчийн дүн	18,201.72	147,647,627.61
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,201.72	156,301,563.82

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	38,941,994.00	391,184,048.10
2	Борлуулалтын өртөг	-	179,560,796.00
3	Нийт ашиг (алдагдал)	38,941,994.00	211,623,252.10
9	Борлуулалт, маркетингийн зардал	38,923,792.28	124,083,890.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	18,201.72	87,539,362.10
19	Орлогын татварын зардал	-	8,753,936.21
20	Татварын дараах ашиг (алдагдал)	18,201.72	78,785,425.89
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	18,201.72	78,785,425.89
24	Орлогын нийт дүн	18,201.72	78,785,425.89
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Халаасны хувьцаа	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	18,201.72	18,201.72
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	18,201.72	18,201.72
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		78,785,425.89	78,785,425.89
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-
14	Өмчид гарсан өөрчлөлт	68,844,000.00		68,844,000.00
15	Зарласан ногдол ашиг			-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
17	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	68,844,000.00	78,803,627.61	147,647,627.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	38,941,994.00	403,913,950.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	38,941,994.00	399,338,195.10
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	4,575,755.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	38,923,792.28	330,308,491.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,941,360.00	66,251,563.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	711,760.00	17,477,366.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,327,200.00	18,362,869.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,673,472.28	45,537,316.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28,670,000.00	162,275,665.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	13,881,857.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	600,000.00	6,521,855.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,201.72	73,605,459.10
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	40,919,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		39,599,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,320,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	(40,919,800.00)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	18,201.72	32,685,659.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,201.72

6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,201.72	32,703,860.82
---	---	-----------	---------------

2.5 Аудит хийсэн батлагдсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Цалин	72,559.0	64,078.5	8,480.5
2	НДШ 12.5%	9,681.4	16,424.6	(6,743.2)
3	Байр ашиглалт	3,600.0	6,300.0	(2,700.0)
4	Гэрэл цахилгаан	60,000.0	40,201.9	19,798.1
5	түлээ, нүүрс	112,000.0	155,372.2	(43,372.2)
6	Цэвэр бохир ус	1,560.0	2,382.9	(822.9)
7	Бичиг хэрэг	1,000.0	562.7	437.3
8	Тээвэр шатахуун	5,000.0	3,188.2	1,811.8
9	Мэдээлэл технологи	1,200.0	250.0	950.0
10	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,245.0	1,284.7	(39.7)
11	Дотоод албан томилолт	2,000.0	1,526.7	473.3
12	Аудитын хөлс	500.0	-	500.0
13	Шуудан холбоо	658.6	33.8	624.8
14	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,000.0	2,625.0	375.0
15	Нормын хувцас	1,000.0	2,714.0	(1,714.0)
16	Хичээл сургалт	2,000.0	-	2,000.0
17	Шаардлагатай тоног төхөөрөмж	3,440.0	18,981.4	(15,541.4)
18	Бараа үйлчилгээний бусад зардал	22,532.6	60,293.2	(37,760.6)
19	Урсгал засвар	107,875.7	7,180.2	100,695.5
	Өмгөөллийн хөлс		2,000.0	(2,000.0)
	Блокны машин		5,500.0	(5,500.0)
	гүйлгээний хураамж		96.6	(96.6)
	Нийт зарлагын төсөв	410,852.3	390,996.6	19,855.7
	Үйл ажиллагааны ашиг	800.0	76,754.2	(75,954.2)
	Нийт дүн	410,052.3	314,242.4	95,809.9

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар **52,063.5** мянган төгрөгийн алдаа¹ илэрч залруулга хийгдлээ. Залруулагдаагүй **441,342.6** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,520.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 431,147.2 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 7,675.4 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж өглөө.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар 52,063.5 мянган төгрөгийн дараах алдаа зөрчлийг залруулсан Үүнд:

Тус үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 52,063.5 мянган төгрөгийн хуримтлагдсан ашгийг зөрүүтэй тусгасныг санхүүгийн тайланд залруулав.

8.2 Төлбөрийн акт

8.2.1. "Хан Оюутын хишиг" ХХК нь 2022 онд дулаанаар хангах гэрээ болон нэхэмжлэхээр 4,000.0 мянган төгрөгийн халаалтын төлбөр төлөхөөс 2,830.0 мянган төгрөгийн төлбөрийг төлж зөрүү 1,170.0 мянган төгрөг төлөгдөөгүй байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.3, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын шаардлагын дагуу дансны авлагыг үнэн зөв тусгаж тайлагнах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын төсөвт дутуу орлогыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

8.2.2. Нэгдсэн халаалтад холбогдсон айл өрх болох С.Сэргэлэн нь 2022 онд дулаанаар хангах гэрээ болон нэхэмжлэхээр 2022 оны 1-5 сарын байдлаар ашигласан дулааны 1,350.0 мянган төгрөгийн халаалтын төлбөрийг төлөөгүй байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.3, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын шаардлагын дагуу дансны авлагыг үнэн зөв тусгаж тайлагнах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын төсөвт дутуу орлогыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

8.3.1. “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хуулийн дагуу дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн дулааны үнийн тарифыг эрх бүхий байгууллагаар батлуулалгүйгээр төсөвт байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхөөс нийт 363,173,400 төгрөгийн халаалтын орлогыг төвлөрүүлсэн байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тусгай зөвшөөрөл авах, үнэ, тариф тогтоолгох арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

8.3.2. Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлөөр баталсан бараа үйлчилгээний бусад зардлаас 2,829.0 мянган төгрөгийг, түлээ нүүрсний зардлаас 16,725.0 мянган төгрөгийг нийт 19,554.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу э-баримтгүй ажил гүйлгээнд зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, 13.7, Төрийн хэмнэлтийн хуулийн 4.1.6, 4.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг таслан зогсоож, ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг хангаж нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

8.3.3. Тайлангийн жилд блокны машин худалдан авахад 5,500.0 мянган төгрөг, өмгөөллийн хөлсөнд 2,000.0 мянган төгрөгийг нийт 7,500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан 2022 оны төсвийн төлөвлөгөөний хөрөнгө оруулалтын зардалд тусгагдаагүй байна.

Энэ нь үйлдвэрийн газрын дүрмийн 6.10.1, 6.10.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг таслан зогсоож, Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

8.3.4. “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаас 40,919,800 төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүй бэлтгэсэн байна.

Энэ нь аймгийн ИТХТ-ийн 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгийг зарцуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

8.3.5. Эрдэнэмандал сумын ИТХТ-ийн 2021.09.13-ны өдрийн 17 дугаар тогтоолоор "Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сумын ЗДТГ-ын дарга З.Батмөнхийг томилж ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.17-д "үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг таслан зогсоож, үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх албан шаардлагыг сумын ИТХ-ын даргад хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аудитаар тус үйлдвэрийн газар нь шилэн дансны цахим хуудасгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын дагуу шилэн дансны цахим хуудас нээлгэх, мэдээллийн хуулийн хугацаанд тогтмол байршуулж ажиллах

2. Батлагдсан төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн 2022.01.27-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан 2022 оны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг дансны хуулга, анхан шатны баримтаар тулган шалгахад 8 нэр төрлийн зардлын ангиллыг батлагдсан зардлын төлөвлөгөөнөөс хэтрүүлэн 108,694.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2022.01.27-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.7.7, 6.10.2, 8.2 дах заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн жилийн бизнес төлөвлөгөөг эдийн засгийн үндэслэлтэй тооцож батлуулах, хөрөнгийг сахилга хариуцлагатай, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах

3. Ногдол ашигтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангийн жилд 76,754.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба сумын орон нутгийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх холбогдох шийдвэрийг гаргуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай, Татварын тухай хуулийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас ногдол ашгийн хэмжээг тооцож, сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	1	52,063.5					1	52,063.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	10	441,342.6	2	2,520.0	5	431,147.2	3	7,675.4	-	-	-	-
